

## Христтэй адил заах тойм

### Есүс Христэд төвлөрөх

Ямар ч зүйл зааж байсан Есүс Христийн талаар заа	Есүс Христэд ирэхэд нь суралцагчдад тусал
Есүс Христийн үлгэр жишээг онцол	Суралцагчдад Их Эзэний хайр, хүч, нигүүлслийг амьдралдаа олж харахад нь тусал.
Есүс Христийн нэр, үүрэг хариуцлага, зан чанарын талаар заа.	Суралцагчдад Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой харилцах харилцаагаа хүчирхэгжүүлэхэд тусал.
Есүс Христийн тухай гэрчлэх бэлгэдлүүдийг эрж хай	Есүс Христтэй илүү адил болохоор хичээл зүтгэл гаргахад нь суралцагчдад тусал.

### Христтэй адил заах зарчим

Зааж байгаа хүмүүсээ хайрла	Сүнсээр заа	Сургаалыг заа	Хичээнгүйлэн суралцахад урь
Суралцагчдыг Бурхан тэднийг хардаг шиг хар.	Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ.	Есүс Христийн сургаалаас бие даан суралц.	Өөрсдөө бие дааж суралцах үүрэг хариуцлага хүлээхэд нь суралцагчдад тусал.
Заадаг хүмүүсийнхээ хэрэгцээ, давуу тал, нөхцөл байдлыг мэдэх замаар тэднийг ойлгохыг эрэлхийл.	Суралцагчдынхаа хэрэгцээний талаарх сүнслэг өдөөлтөд хариулахад үргэлж бэлэн бай.	Судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын үгсээс заа.	Аврагчаа таньж мэдэхийн тулд сайн мэдээнээс өдөр бүр суралцдаг байхад суралцагчдаа урамшуул.
Тэдний төлөө нэрийг нь хэлэн залбир.	Суралцагчдад Ариун Сүнсний хүчээр заахын тулд таатай орчин бүрдүүл.	Судрын үнэнүүдийг эрж хайн, танин мэдэж, ойлгоход нь суралцагчдад тусал.	Тэднийг суралцахаар бэлтгэхэд урь.
Бүх хүнд хүндлэл болон өөрсдийнх нь оролцоо үнэ цэнтэй болохыг мэдрэх аюулгүй орчныг бүрдүүл.	Хувийн илчлэлт эрэлхийлж, таньж мэдэн, түүнийхээ дагуу үйлдэхэд нь суралцагчдадаа тусал.	Есүс Христэд хөрвөгдөж, Түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд хөтлөх үнэнүүд дээр төвлөр.	Суралцагчдыг суралцаж байгаа үнэнийхээ талаар хуваалцахад урамшуул.
Хайраа илэрхийлэх тохиромжтой аргыг ол.	Гэрчлэлээ тогтмол хуваалцаж, суралцагчдыг мэдрэмж, туршлага, гэрчлэлээ хуваалцахад урамшуул.	Есүс Христийн сургаалаас өөрсдөдөө хамааралтай зүйлсийг олж мэдэхэд нь суралцагчдад тусал.	Суралцаж байгаа зүйлээ тунгаан бодоход тэднийг урь.